

**МОНГОЛЫН СКАУТЫН ХОЛБООНЫ НАСАНД
ХҮРЭГЧДИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Скаутын хөдөлгөөн Монголд үүсэн хөгжөөд 15 жил болсон бөгөөд бидний үйл ажиллагаа өргөжин хөгжиж, төрийн болон төрийн бус байгууллагууд, хүүхэд залуучуудын дунд байгууллагын нэр хүнд өссөөр байна.

Гэвч сүүлийн үед скаутын удирдагч нарын дунд зарим үйл ажиллагааны үеэр ёс зүйн алдаа дутагдал гаргах болсон нь скаутын байгууллага, удирдагч нарын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ үүднээс скаутын насанд хүрэгчдийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг үнэлж дүгнэх журам, дүрмийг боловсруулан баталж мөрдөх шаардлагатай юм.

Энэхүү ёс зүйн дүрэм нь Монголын Скаутын Холбооны гишүүн насанд хүрэгч хэн бүхэнд адилхан үйлчлэх юм. Скаутын насанд хүрэгч гэдэгт 18 нас хүрсэн, скаутын андгай өргөсөн роверууд, сайн дурынхан, бүлгийн удирдагчид, сонгуульт гишүүдийг хамруулна.

Нэг. Скаутын насанд хүрэгчдийн ёс зүйн дүрмийн зорилго

1.1 Скаутын бүхий л үйл ажиллагааны үед Скаутын удирдагчид ба скаутуудын хооронд үүсэх ёс суртахууны харилцааг зохицуулж, скаутын удирдагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэн, Скаутын удирдагчийн нэр төрийг нь хамгаалахад оршино.

1.2 Скаутын удирдагчийн ёс зүйн зөрчил нь скаутын хөдөлгөөнд нэгдэн хөгжиж буй өсвөр үеийнхний сэтгэл зүйд нөлөөлөхөөс улбаалан гишүүнчлэл, скаутын нэр төрд харшлах тул скаутын удирдагчийн ёс зүйн дүрмийг заавал мөрдөх үүрэгтэй.

Хоёр . Скаутын насанд хүрэгчдийн ёс зүйн хэм хэмжээ

2.1. Скаутын эрхэм зорилго, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө скаутын насанд хүрэгчид, удирдагч багш нар эрх, үүргээ биелүүлж, скаутын гишүүдийг скаутын арга зарчмаар хөгжүүлэх үйл ажиллагааныхаа хүрээнд:

2.1.1. Скаутын гишүүдийг нийгэм-соёлын ялгаатай байдал, нийгмийн гарал, эцэг эх асран хамгаалагчдынх нь боловсрол, амьжиргааны түвшин, өөрийн нь суралцах чадвар, гадаад өнгө үзэмжээр нь ялгаварлахгүйгээр хандаж байх,

2.1.2. Скаутын удирдагч нар скаутын гишүүдэд тавих шаардлага нь тэдний бие бялдар, оюун ухаан, нийгмийн хөгжлийн онцлог байдалд тохирсон байх бөгөөд тогтоосон журмыг зөрчиж, гэр бүлийн байдал, хүүхдийн хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлан скаутын төрөл бүрийн үйл ажиллагаанаас хөөхгүй байх.

2.1.3. Хүүдүүдийн хувийн нууцийг чанд хадгалан, тэдний нэр төр, үзэл бодлыг үгээр басамжлан доромжлох, бие махбодийн шийтгэл үзүүлэхгүй байх,

2.1.4. Скаутын аялал, зуслан, цугларалтын үерээр скаутын удирдагч нь скаутын хүүхдийн майханд хонох, тамхи татах, согтууруулах ундааг хэрэглэхгүй байх

2.1.5. Скаутын холбогдолтой эд зүйлсийг тулган борлуулахгүй, төлбөр, хураамж, хандив өгөхийг шаардахгүй байх

2.1.6. Скаутын удирдагчийн нэр хүндийг ямагт дээдлэн, биеэ авч яваа байдал, хөгжих үйл ажиллагаа, хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээж, скаутын төрөл бүрийн үйл ажиллагаа, сургалтын зөв үйл явцыг дэмжин идэвхтэй хандах,

2.1.7. Скаутын төрөл бүрийн үйл ажиллагаанд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, бэлгийн дарамт, гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхэн болон гэр бүл, нийгмийн орчны сөрөг нөлөөнд автуулахгүй байхад нь анхаарах.

2.2. Скаутын удирдагчийн нэр хүндийг эрхэмлэн эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах хүрээнд:

2.2.1. Хүүхдүүдийн эцэг эхийг нас, хүйс, яс үндэс, боловсрол, шашин шүтлэг, улс төрийн үзэл, амьдралын нөхцөлөөр үл ялгаварлан, скаутын үйл ажиллагаанд гэр бүл, эцэг эхийг нээлттэй тэгш оролцуулах,

2.2.2. Скаутын үйл ажиллагааны чанартай холбоотой эцэг эхийн санал, шаардлагыг хүлээн авч, хүүхдэд нь хамаарах асуудлаар эцэг эхэд нь зөв шаардлага тавих,

2.2.3. Скаутын удирдагчийн үүргээ хэрэгжүүлсний төлөө эцэг эхээс шан харамж авах, бэлэг өгөхөөс аргагүй байдалд тухайн хүүхэд болон тэдний асран хамгаалагчид, эцэг эхийн зөвлөлийн зөвшөөрлийг авсан байх,

2.3. Хамт олны бүтээлч, нөхөрсөг, шударга өрсөлдөөнийг хангасан орчин төлөвшүүлэхийг эрмэлзэж, хамтран ажиллах хүрээнд:

2.3.1. Хамтран ажиллагчдынхаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг, туршлагаар нь ялгаварлахгүйгээр хүндэтгэлтэй харилцах,

2.3.2. Өөрийн болон байгууллагын нэр хүнд, амжилтын төлөө хамт олон, хувь хүний нэр төр, эрүүл мэнд, сэтгэл санаа, хувийн өмчид хохирол учруулахгүй байх,

2.3.3. Скаутын арга, зарчим, төрөл бүрийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн туршлагаа бусадтай хуваалцан, хувийн болон байгууллагын эрх ашгийг зөв хослуулж, хамт олны эв нэгдлийг дээдлэх

2.3.4. Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохдоо хариуцлагатай хандаж, хамтын хариуцлага хүлээнэ

2.3.5 Скаутын удирдагч нь өөрийн үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн үзэл бодол, улс төрийн байр суурь, шашин шүтлэг зэргийг скаут хүүхдүүд, эцэг эх, хамт олонд тулган хүлээлгэх, уриалах, үүний улмаас өөрийн болон бусдын үндсэн ажил орхигдоход хүргэхийг цээрлэх,

2.4. Скаутын удирдагч нарт хориглох зүйлс

2.4.1 Хүүхдийн эрхэнд халдах.

2.4.2 Скаутын үйл ажиллагааг эдийн засгийн сонирхлын үүднээс ашиглаж хөрөнгө санхүүгийн асуудалд холбогдох.

2.4.3 Хүүхэд болон насанд хүрэгчдийг хүчирхийлэх гэж оролдсон, хүчирхийллийн шинжтэй үйлдэл гаргах.

2.4.4 Скаутын үйл ажиллагаанаас олсон орлого, эд материал зэргийг өөрийн хувийн эд зүйл болгох.

Гурав. Скаутын насанд хүрэгчдийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт

3.1. “Скаутын удирдагчийн ёс зүйн дүрэм”-ийн заалтуудыг зөрчсөн скаутын насанд хүрэгчдийг скаутын төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх, скаутын байгууллагын гишүүнчлэлээс хасах, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх хүртэл арга хэмжээ авна,

3.2. Ёс зүйн зөрчил гаргасан скаутын удирдагч нарт хүлээлгэх хариуцлага нь нийгэм, байгууллага, скаутын гишүүдэд учруулсан хор хохиролд нь тохирсон байна.

3.3 Скаутын удирдагч нар ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд

- Сануулах
- Түр хугацаагаар скаутын үйл ажиллагаанд оролцох эрхийг хасах /6 сараас дээш хугацаагаар/
- Скаутын хөдөлгөөнөөс хөөх

3.4 Дараах төрлийн ёс зүйн зөрчил гаргасан тохиодолд шууд хөөх шийтгэлийг оногдуулна. Үүнд:

- Хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн
- Санхүүгийн ноцтой зөрчил гаргасан
- Скаутын үйл ажиллагааны үеэр согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж зохисгүй ааш авир гаргасан,
- Хүүхэд болон насанд хүрэгчдийг хүчирхийлэх гэж оролдсон, хүчирхийллийн шинжтэй үйлдэл гаргах

3.5. Хяналтын алба болон ҮТШ, Аймаг, нийслэл, дүүргийн Скаутын зөвлөл нь “Скаутын насанд хүрэгчдийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийн биелэлтэнд хяналт тавин шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

3.6. Ёс зүйн зөрчлийн талаар ирүүлсэн албан бичиг, бичгээр гаргасан гомдлыг үндэслэн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж, холбогдох байгууллага болон гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.

3.7. Скаутын насанд хүрэгчдийн ёс зүйн байдлын талаарх дүгнэлтийг харъяалагдах Скаутын Зөвлөлийн дарга болон өөрт нь хүргүүлэх ба дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

3.8. Ёс зүйн зөрчилд ногдуулсан хариуцлагыг үндэслэлгүй эсвэл хүндэдсэн гэж үзвэл тухайн насанд хүрэгч 30 хоногийн дотор бичгээр гомдлоо гаргаж болно.